



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/134

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай салбарын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 40.000.000 (Дөчин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 40.000.000 (Дөчин сая) төгрөгийг Засаг дарга дансны "Хууль сахиулах байгууллагын албан хаагчийг орон нутагт томилогдоход тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор шаардлагатай дэмжлэг үзүүлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН